



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

“Баянзүрх дүүргийн Миний зөвлөгч”
өрхийн эрүүл мэндийн төвийн данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1629 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 6,300,000 (зургаан сая гурван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэгдэл өртөггүй тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг “Баянзүрх дүүргийн Миний зөвлөгч” өрхийн эрүүл мэндийн төв (С.Амаржаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг “Баянзүрх дүүргийн Миний зөвлөгч” өрхийн эрүүл мэндийн төв (С.Амаржаргал)-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500304

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2024 оны 12 дугаар сарын 12 ны өдрийн
 ... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгсэл

№	Байгууллагын нэр	Автомашинны марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн он, Монголд ашиглаж эхэлсэн огноо	Арлын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Сэлбэг буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах доод үнэ /төгрөг/
1	"Баянзүрх дүүргийн Миний зөвлөгч" ӨЭМТ	Минцубиши миникаб 63-06УНЦ	2003/2010	U61V0914468	6,300,000	6,300,000	0,00	300,000
Дүн					6,300,000	6,300,000	0,00	